

Улаанбурхан өвчний эсрэг вакцинжуулалтын талаарх хүн амын мэдлэг, хандлага

*Номин-Эрдэнэ Б., Ичинхорлоо Б., Ариунтөгс С., Анхмаа Б., Төгөлдөр Б., Гансмаа М., Бүдханд О.,
Халиунаа Т., Номин Б., Сайнбаяр Ц., Оюунбилэг Ж.*

*Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
E-mail: naomi_2324@yahoo.com*

Abstract

Knowledge and attitude of population on measles vaccination

*Nomin-Erdene B., Ichinkhorloo B., Ariuntugs S., Ankhmaa B., Tuguldur B., Gansmaa M., Budkhand O.,
Khaliunaa T., Nomin B., Sainbayr Ts., Oyunbileg J.*

*National Center for Public Health
e-mail: naomi_2324@yahoo.com*

Introduction

Vaccination is a cost-effective intervention to prevent major illnesses that contribute to child mortality in the country. Increase in parental knowledge about vaccination will lead to increase in vaccination rates of children. The main aim of our study was to assess the knowledge, attitudes and perceptions of vaccination. People's knowledge about immunization and their attitudes toward them are likely influence uptake.

Goal

The main purpose of the study is to evaluate the knowledge and attitude of the population towards measles and to clarify their satisfaction and understanding of the measles immunization program.

Materials and Methods

We conducted cross-sectional study, involved participants from 3 aimags and 6 districts covered voluntarily. Total participants were 509. We used to online model and with the participant's self-answer closed questionnaire.

Results

76% of the respondents were female and 24% were male. 64.1% of respondents who have children of 0 to 5 years of age, had little or bad knowledge towards immunization schedules against measles. Overall, the general attitude towards vaccines was positive, but the knowledge about significance of vaccines was weak. Further, district and province family doctors need to pay particular attention to increasing awareness and knowledge on importance of vaccines among families with young children. It is necessary to conduct extensive, long-term research and training among population to evaluate their knowledge and attitude towards measles, its vaccine and prevention, and to identify causes of lack of knowledge.

Conclusion

Our study shows the importance of good physician–patient communication in improving knowledge attitude and practice of parents towards their children's vaccination.

Key words: Knowledge, measles, vaccination awareness

Pp. 52-57, Table 1, Figures 6, References 16

Үндэслэл

Улаанбурхан өвчний үүсгэгч нь Morbillivirus – ийн овгийн Paramyxoviridae бүлгийн 120-230 нм хэмжээтэй бөөрөнхий хэлбэртэй, дан мушгиат РНХ агуулсан вирус юм. Улаанбурхан өвчин нь амьсгалын замаар дамжин халдварладаг, ханиалгах, нус гоожих, нүд улайх, өндөр халуурах зэрэг эмнэлзүйн шинж тэмдгээр илэрдэг хурц халдварт өвчин юм. Уушгины үрэвсэл, дунд чихний үрэвслээр хүндэрдэг. Улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтад хамрагдаагүй тохиолдолд өвдөх эрсдэлтэй өндөр байна [1].

ДЭМБ-ын мэдээлж байгаагаар, дархлаажуулалтын үр дүнд 2000 оноос хойш улаанбурхан өвчний улмаас нас баралт 75%-иар буурчээ. Өнгөрсөн онд Энэтхэг, Тайланд, Бангладеш, Филиппин, Малайз, Япон, Украин, Итали зэрэг оронд тус өвчин дэгдсэн. Монгол улсад улаанбурхан өвчин хамгийн их дэгдсэн нь 2015, 2016 он бөгөөд тухайн үед өвчний шинж тэмдэг илэрсэн 50 мянган хүн бүртгэгджээ [2].

Хүүхэд насанд ихэвчлэн тохиолддог, халдварлалтын түвшин 95% буюу халдварлалт өндөртэй гэж үздэг. Улаанбурханы вакцин хийж эхлэхээс өмнө АНУ-д жилд 4 сая хүүхэд өвчилж 500 нь нас бардаг байсан. Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ-MMR) эсрэг гурван цэнт вакцинаар дархлаажуулсны дүнд 2000 онд АНУ-д улаанбурхан өвчний тархалтыг таслан зогсоосон байна [7]. 2019 онд АНУ-д улаанбурхан өвчний 63 тохиолдол бүртгэгдсэн нь бусад улс орноос тус улсад ирж суурьшсан дархлаажуулалтад хамрагдаагүй хүүхдүүд байсан байна [3].

Вакцины аюулгүй байдал бол эцэг эхчүүдийн анхаарал татсан асуудал байдаг тул эрүүл мэндийн ажилтнууд ухуулга сурталчилгааг үнэн зөв хийж, вакцин хийлгэх саналыг хүүхдийн эмнэлгээс мэргэшсэн эмч, мэргэжилтнүүд

санал болгох хэрэгтэй гэж Шведийн судлаачид дүгнэсэн байна [4, 5].

Дархлаажуулалтын хамралт нэмэгдэн өвчлөл буурч байгаа хэдий ч өвчний тохиолдол хангалттай буурахгүй байгаа нь хүн амын дунд улаанбурхан, бусад халдварт өвчин, урьдчилан сэргийлэх аргууд, вакцины талаарх мэдлэг, хандлагыг судалж, цаашид сурталчилгаа, сургалт явуулах арга замыг тогтоох шаардлагатай байна.

Зорилго

Улаанбурхан өвчин, түүний эсрэг урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын талаарх хүн амын мэдлэг, хандлагыг үнэлэх

Материал, арга зүй Судалгааг нэг агшингийн загвараар, улсын хэмжээнд явуулахаар тогтож, судалгааны асуумжийг цахимаар хүргүүлэв. Гадаадын орнууд (АНУ, Канад, Швед)-д хийгдсэн ижил төстэй судалгаанд тулгуурлан бидний тусгайлан боловсруулсан хаалттай асуумжийг ашиглав. Судалгаанд хамрагдагсад сайн дураараа оролцсон.

Цахим асуумж судалгаа нь ерөнхий хэсэг, улаанбурхан өвчний тухай ойлголт, уг өвчнөөс сэргийлэх вакцины талаарх мэдлэг, хандлагын асуултуудыг багтаасан бөгөөд судалгааны мэдээллийг Google Docs программ ашиглан цуглуулав.

Судалгаанд оролцогчдийн улаанбурхан өвчний талаарх мэдлэг, хандлагын байдлыг нас, хүйс, байршилтай холбон Google Docs, SPSS 19.0 программ ашиглан мэдээлэлд боловсруулалт хийв.

Үр дүн

Баянзүрх, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Төв, Орхон, Архангай аймгийн иргэд цахим судалгаанд оролцсон байна (Хүснэгт 1).

Table 1. General information of respondents', by gender, age and region

Performance	Age	Selected individuals, number	Participation, %
Age group	<18	21	4.1
	18-24	116	12.8
	25-34	232	45.6
	35-44	83	16.3
	45-65	55	10.8
	>65	2	0.4
Gender	(woman)	387	76
	(man)	122	24
Region	Ulaanbaatar	260	51
	Province	249	49
Total		509	100

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 76% нь эмэгтэй, 24% нь эрэгтэй оролцогч байв.

нь вакцин хийлгэхийг дэмждэг харин 4.3% нь дэмждэггүй байна (Зураг 1).

Нийт судалгаанд оролцсон хүмүүсийн 95.7%




Figure 1. Support vaccination

Судалгаанд хамрагдсан хүн амаас улаанбурхан өвчний талаарх ойлголтыг тодруулахад 62.5%

нь мэднэ, гэхдээ хангалттай биш гэж хариулжээ (Зураг 2).




Figure 2. Participant's knowledge and attitude on measles

Улаанбурхан өвчний үед илрэх шинж тэмдгийн алаарх асуултад 53.3% нь өндөр халуурдаг, 75.3% нь арьсан дээр улаан өнгийн гүвдүүт

тууралт гардаг, 25.6% нь толгой өвдөх шинж тэмдэг илэрнэ, 15% нь мэдэхгүй гэжээ (Зураг 3).




Figure 3. Knowledge about clinical symptoms of measles

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 43.6% нь хүүхдийг хэдэн сар/настайд нь улаанбурхан

өвчний эсрэг вакцинд хамруулдаг талаар мэдэхгүй байна (Зураг 4).




Figure 4. Knowledge about vaccination schedule of measles

Нийт судалгаанд оролцогчдын 64.1% нь 0-5 насны хүүхэдтэй, 45.5% нь 6-15 насны

хүүхэдтэй, 20.6% нь 15-с дээш насны хүүхэдтэй иргэд байв (Зураг 5).




Figure 5. Age groups of the surveyed children

Судалгаанд нийт 509 хүн хамрагдсан ба судалгаанд хамрагдсан хүмүүсийн 48% нь улаанбурхан өвчний эсрэг вакцинжуулалтад хамрагдсан бол 22% нь улаанбурхан өвчний

эсрэг вакцинжуулалтад хамрагдсан эсэхээ мэдэхгүй, 30% нь хамрагдаагүй гэсэн хариултыг өгчээ (Зураг 6).




Figure 6. The status of administration on measles vaccine

Манай улсад улаанбурхан өвчний эсрэг вакциныг үндэсний товллын дагуу 9 сартайд болон 2 настайд хийдэг. Судалгаанд оролцогчдын 43.6% нь хүүхдийнхээ хэдэн сар/настайд улаанбурханы вакцин хийлгэгдгийг мэдэхгүй байна.

Хэлцэмж

Дэлхийн хэмжээнд 1980 оноос хойш улаанбурхан өвчинд хүүхдийн өртөлт эрс буурсан хэдий ч сүүлийн жилүүдэд өвчлөл дахин сэргэж байна [3]. Өвчлөл, дархлаажуулалтын байдалд эцэг эхийн мэдлэг, хандлага ихээхэн нөлөөлдөг.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 95.7% нь улаанбурхан өвчний эсрэг вакцинжуулалтын талаар эерэг сайн хандлагатай байна. Weiss C., Merten S. нар (2016)-ын улаанбурхан өвчний талаарх эцэг эхчүүдийн хандлагыг үнэлсэн судалгааны дүнгээс харахад асуумж судалгаанд хамрагдсан нийт эцэг, эхчүүдийн 90% нь вакцинжуулалтын талаар эерэг хандлагатай бөгөөд шаардлагатай бол хүүхдээ вакцинжуулахыг дэмждэг гэсэнтэй бидний судалгааны үр дүн дүйж байна [4].

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дийлэнх нь улаанбурхан өвчний вакцинжуулалтын талаарх хандлага сайн байгаа хэдий ч уг өвчний үед ямар шинж тэмдэг илрэх, өвчний шинж тэмдэг илэрсэн үед хаана хандахаа мэдэхгүй, вакцинжуулалтад хамрагдсан эсэхээ мэдэхгүй гэж хариулжээ. Иймд цаашид нийт хүн амын дунд нас, хүйс, нийгмийн янз бүрийн давхаргыг хамруулсан улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалт болон түүний ач холбогдлын талаарх сурталчилгааг өргөжүүлэх, эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн онлайн судалгаанд хамрагдсан цөөн хүмүүс вакцинжуулалтыг дэмждэггүй гэсэн байна. Иймд цаашид вакцинжуулалтыг дэмждэггүй хүн амын дунд дахин урт хугацааны судалгаа хийж шалтгааныг тодруулах нь зүйтэй. Учир нь

вакцинжуулалтыг дэмждэггүй хүн амын дундах вакцины аюулгүй байдал, үр дагаврын талаарх эргэлзээ, цахим орчинд тархаж буй буруу ташаа мэдээлэл, зөрүүтэй ойлголтыг арилгах нь хүүхдээ вакцинжуулалтад хамруулахгүй байхыг бууруулах ач холбогдолтой юм. Breiger D., Whitehall J. нар (2017)-ын судалгаагаар нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 8% нь вакцинжуулалтад хамрагдаагүй байсан байна. Эдгээр хүмүүс нь вакцины тухай мэргэжлийн эмчээс зөвлөгөө аваагүй, нийгмийн сүлжээ, мэргэжлийн бус хүмүүсээс сонссон байснаас шалтгаалан вакцины аюулгүй байдал, үр нөлөөнд эргэлздэг төдийгүй гаж нөлөөтэй гэж үзсэн байна [5].

Канадын судлаачид хүүхэддээ вакцин хийлгэх шийдвэр гаргахад олон хүчин зүйлс нөлөөлөх боловч хамгийн гол нь хүүхдийн эхийн хандлага чухал нөлөөтэй болохыг илрүүлсний дараа уламжлалт аргаа өөрчлөн шинэ арга зүйгээр ухуулга нөлөөлөл, сургалт явуулсны дараа эцэг, эхчүүдийн сонголт, сэтгэл зүйн байдал нь өөрчлөгдөж байсан байна. Энэ нь зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой сургалт, сурталчилгааг зөв аргаар явуулах ач холбогдолтойг харуулж байна [13].

M.Evans, H.Stoddart нар (2001)-ын судалгаагаар улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг гурван цэнт вакцины ач холбогдол, эрсдэлийн талаарх мэдээллээр эцэг, эхчүүдийг дархлаажуулалтын цэгт ирэхээс өмнө хангасан байх нь вакцинд итгэх итгэлийг нэмэгдүүлж, шийдвэр гаргалтад нөлөөлдөг нь тогтоогдсон байна [14].

Вакцинжуулалтын талаарх мэдлэггүй байх нь өвчнөөс сэргийлэх, вакцин хийлгэхээс татгалзах, хоцроох, айдас төрүүлэх шалтгаан болох тул эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд мэргэжлийн үүднээс зөв тайлбарлаж ойлгуулах нь чухал юм [15, 16].

Ялангуяа бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүд, нийгмийн өөр өөр давхрагын, хэл соёл, зан заншлын хувьд ялгаатай хүн амын дунд улаанбурхан өвчин, түүнээс сэргийлэх вакцины талаарх зөв мэдээлэл, мэдлэг ойлгох сургалтуудыг давтамжтайгаар байнга зохион байгуулах, хандлагыг үнэлэх, мэдлэггүй байгаа шалтгааныг олж тогтоон, ганцаарчилсан, бүлгийн болон тодорхой хэсэгт чиглэсэн сургалтыг урт, богино хугацаанд явуулах, бусад орны сайн туршлагуудыг нэвтрүүлэх, эцэг, эхчүүдийн дунд хэлэлцүүлэг явуулах зэрэг өргөн цар хүрээтэй ажлыг мэргэшсэн эмнэлгийн ажилтнууд зохион байгуулах шаардлагатай. Ингэснээр улаанбурхан өвчний

эсрэг вакцинжуулалтын эргэлзээг арилгаж, хамрагдалтыг нэмэгдүүлэх боломжтой.

Судалгааны хязгаарлагдмал тал

Энэхүү судалгаа нь цахим хэлбэрээр, интернет орчинд байршуулан оролцогчид өөрсдөө бөглөх хаалттай асуумжийн хэлбэрээр явуулсан бөгөөд нийт аймгийн төлөөлөл оролцоогүй тул цаашид улсын хэмжээнд уг судалгааг хийх шаардлагатай юм.

Дүгнэлт:

Цахим хэлбэрээр судалгаа явуулахад эрэгтэйчүүдийн оролцоо, идэвхи бага байв. Хүүхдээ товлолын вакцинд хамруулахад аавуудын оролцоог нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх, сургалт, сурталчилгааг сонирхол татахуйц хэлбэрээр явуулах шаардлагатай байна.

Судалгаанд оролцогчид вакцины талаар ерөнхийдөө эерэг хандлагатай боловч вакцины ач холбогдлын талаарх мэдлэг сул байна.

Бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүд судалгаанд хамрагдагчдын дийлэнх хувийг эзэлж байгаа боловч улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалт, товлолын хугацаа, вакцины ач холбогдлын талаарх мэдлэг муу байгаа нь вакцинжуулалтын талаарх сургалт, сурталчилгааг насны бүлэг, хүйсээр ангилан, мэдээллийг олон хэлбэрээр, хүртээмжтэй явуулах шаардлагатайг харуулж байна.

Ном зүй

1. Жефри Поммервилл, Бичил Амь Судлалын Үндэс, Жийсом Пресс ХХК, 2014, х.621-623
2. Measles vaccines: WHO position paper- April 2017, Weekly Epidemiological Record, 92 (17), 205 - 227
3. Y.Krishnamoorthy, M.Sakithivel, SK.Elivas, G.Surendran and G.Sarveswaran; Worldwide trend in measles incidence from 1980 to 2016: A pooled analysis of evidence from 194 WHO Member States; 2019 Jul-Sep; 65(3): 160–163. doi: 10.4103/jpgm.JPGM_508_18
4. R Alfredsson , E Svensson, B Trollfors, M P Borres, Why do parents hesitate to vaccinate their children against measles, mumps and rubella?, Acta Paediatr, 2004 Sep;93(9):1232-7
5. Eva Dannetun, Anders Tegnell, Gүran Hermansson, Johan Giesecke, Parents' reported reasons for avoiding MMR vaccination. A telephone survey, Scand J Prim Health Care, 2005 Sep; 23(3):149-53
6. Weiss.C, Schropfer.D, Merten.S; Parental

attitudes towards measles vaccination in the canton of Aargau, Switzerland: a latent class analysis; 2016 Aug 11;16(1):400. doi: 10.1186/s12879-016-1747-0

7. Bieger.D, Edwards.M, Mudgii.P, Whitehall.J; Knowledge, attitudes and opinions towards measles and the MMR vaccine across two NSW cohorts; 2017 Dec;41(6):641-646. doi: 10.1111/1753-6405.12720. Epub 2017 Sep 12; DOI:10.1111/1753-6405.12720
8. CDC. Measles (rubeola): measles elimination. Atlanta, GA: US Department of Health and Human Services, CDC; 2019. <https://www.cdc.gov/measles/elimination.html>
9. McLean HQ, Fiebelkorn AP, Temte JL, Wallace GS. Prevention of measles, rubella, congenital rubella syndrome, and mumps, 2013: summary recommendations of the Advisory Committee on Immunization Practices (ACIP). MMWR Recomm Rep 2013;62(No. RR-04).
10. Dabbagh A, Laws RL, Steulet C, et al. Progress toward regional measles elimination-worldwide, 2000–2017. MMWR Morb Mortal Wkly Rep 2018;67:1323–9. <https://doi.org/10.15585/mmwr.mm6747a6>
11. Banerjee E, Griffith J, Kenyon C, et al. Containing a measles outbreak in Minnesota, 2017: methods and challenges. Perspect Public Health 2019. <https://doi.org/10.1177/1757913919871072>
12. Orenstein WA, Markowitz L, Preblud SR, Hinman AR, Tomasi A, Bart KJ. Appropriate age for measles vaccination in the United States. Dev Biol Stand. 1986; 65:13–21
13. Deborah A McNeil , Melissa Mueller, Shannon MacDonald, Sheila McDonald, Vineet Saini, James D Kellner, Uzanne Tough, Maternal perceptions of childhood vaccination: explanations of reasons for and against vaccination, BMC Public Health, 2019 Jan 10;19(1):49
14. M.Evans, H.Stoddart, L.Condon, E.Freeman, M.Grizzell, R.Mullen. Parents' perspectives on the MMR immunisation: a focus group study, Br J Gen Pract, 2001 Nov;51(472):904-10.
15. D.Jewell, MMR and the age of unreason, Br J Gen Pract, 2001 Nov;51(472):875-6
16. D.Elliman, H.Bedford, MMR immunisation. Health professionals should strongly recommend this immunization, BMJ, 2001 Oct 13;323(7317):869.

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор П.Энхтуяа*